



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

124 /124/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.08.31

ҮЙЛ ЯВДАЛ



ХЭЭРИЙН СУРГУУЛЬ БАРУУН БҮСЭД ...

Батлан хамгаалах салбарын багц хуулиудын хэрэгжилтийг хангах нь Зэвсэгт хүчний үйл ажиллагааны үндсэн гол чиглэл юм. Эдгээр багц хуулиудын нэг гол хууль болох "Зэвсэгт хүчний тухай" Монгол Улсын хуульд УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар нэмэлт өөрчлөлт оруулж Зэвсэгт хүчин нь хуурай замын цэрэг, агаарын цэрэг, барилга-инженерийн цэрэг, кибер аюулгүй байдлын цэрэг болон тусгай хүчний цэргээс бүрдэнэ гэж заасан. Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөнд шинээр байгуулагдсан төрлийн цэргийн командлалуудын харилцан

ажиллагааг төлөвшүүлэх, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог төгөлдөржүүлэх зэрэг хэд хэдэн томоохон зорилтууд тусгагдсан.

Эдгээр зорилтуудын хүрээнд баруун бүсийн Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарууд оролцсон байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулагдав. Хэд хэдэн үе шаттай явагдсан тус сургууль нь Завхан, Ховд, Баян-Өлгий аймгуудын газар нутгийг хамран нэлээд өргөн бүрэлдэхүүнтэй явагдсан, орон нутгийн цэргийг дайчлан богино хугацааны эрчимжсэн сургалтаар жигдрэлтийг хангаж оролцуулсан, уламжлалт бус аюул заналын

үед жижиг бүлгээр байлдааны ажиллагааг идэвхтэй явуулах, тэр дундаа ердийн хөсөг, морь, мотоцикл зэргээр орон нутгийн цэргийн үүрэг гүйцэтгэх, маневрлах боломжийг нэмэгдүүлсэн зэргээс гадна сүүлийн жилүүдэд ийм сургууль явагдаагүй гэдгээрээ чухал ач холбогдолтой сургууль боллоо.

Тус байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн талаар сургуулийн удирдагч, бригадын генерал Ч.Цогжаргал онцлохдоо "Энэхүү сургууль явагдсанаар эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах

Зэвсэгт хүчний үндсэн чиг үүргийн дагуу цагийн байдлын ямар ч нөхцөлд тогтоосон хугацаанд дээд командлалаас даалгасан үүргийг мадаггүй биелүүлэх Зэвсэгт хүчний байлдааны бэлэн байдалд "цэргийн мэргэжлийн болон захиргааны удирдлага"-ыг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн хүч, хэрэгслийг зохион байгуулалттайгаар хэрэглэн "цэргийн ажиллагаа" явуулах, тайван цагт болон дайны үед Зэвсэгт хүчнийг ашиглах "Төрийн цэргийн номлол" хэрэгжүүлэх цаашид боловсронгуй болгоход ихээхэн туршлага, сургамж болсон арга хэмжээ боллоо" гэв.



ЦДБЭЧ ЗАРИМ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨ ШИНЭЧЛЭВ



БХЯ-наас ЦДБЭЧ-ын Тайзны албаны хэрэгцээт аппаратур тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд "Саннилайф" ХХК-аас "Midas M32" маркийн дуугаралтын удирдлагын пульт, утастай, утасгүй микрофон тэргүүтэй 10 нэр төрлийн 38,599,000 төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг ЦДБЭЧ-ын тайзны албанд хүлээлгэн өглөө.

Батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт

хүчний үйл ажиллагааг урлаг соёлоор дамжуулан сурталчлах, цэрэг эх орны сэдэвтэй уран бүтээлүүдийг ард иргэд, цэрэг дайчдад хүргэж, түгээн дэлгэрүүлэхэд тус чуулга чухал үүрэгтэй. Тийм ч учраас тэдний тоглолт үйлчилгээнд хүчин чадал сайтай тоног төхөөрөмж, аппаратур техник хэрэгсэл нэн чухал бөгөөд чуулгын удирдлага шинэчлэлтийн ажлыг ийнхүү шат дараалан хийсээр байна.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 212,075 +2209	ЭДГЭРСЭН 192,845 +1795	НАС БАРСАН 930 +4
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4590 +80	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 172 +15	ЭДГЭРСЭН 4329 +16
-----------------------------	--------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 217,866,804
Эдгэрсэн Нийт: 194,712,254
Нас барсан Нийт: 4,522,938

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 23	🌙 7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 35	🌙 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.848.0	2.850.0
EUR 🇪🇺	3.358.0	3.370.0
CNY 🇨🇳	441.0	442.0
RUB 🇷🇺	38.20	39.40
JPY 🇯🇵	25.41	26.16
KRW 🇰🇷	2.40	2.49

ЗУРХАЙ

2021.08.31 МЯГМАР ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 24/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН
БИЧ САРЫН НАЙМАН
ЦАГААН ЦАГААГЧИН
ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ
Наран ургах, шингэх:
06.09-19.36
Барилдлага:
Хүчин төгсөх
Шүтэн барилдлага:
Өтлөх үхэхүй
Суудал:
Огторгуй

Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, сан тавиулах, угаал үйлдэх, нялхсын хурим хийх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаг гаргах, сэтгэлд сэвтэй газар очих, багадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ СУРГАЛТААР ...



Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам"-д нийцүүлэн алба хаах тухай гэрээ байгуулан, Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/211 дүгээр тушаалаар батлагдсан "Цэргийн дүйцүүлэх албаны сургалтын хөтөлбөр"-ийн дагуу аймгийн Засаг даргын 2021 оны А/289

дүгээр захирамжаар цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалтыг зохион байгуулав.

Сургалтыг 8 дугаар сарын 9-24-ний өдрүүдэд 16 хоногийн хугацаатай Их-Уул сумын Зарт багийн нутагт байрлах Зартын рашаан сувиллын газрыг түшиглэн явуулсан юм.

Сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнд хөтөлбөрийн дагуу хичээл сургуулийг 12 хоногийн хугацаанд өдөрт 8 цагаар зохион байгуулан явуулж батлан хамгаалах

салбарын бодлого, үйл ажиллагаа, хууль эрх зүйн шинэчлэлийн талаар мэдээлэл өгч, цэргийн анхан шатны бэлтгэлийг эзэмшүүлэв. Түүнчлэн сургалтад хамрагдсан бүрэлдэхүүн Зартын рашаан сувиллын газрын тохижилт бүтээн байгуулалтын ажил /хуучин байшин буулгаж цэвэрлэх, ариун цэврийн байгууламж барих, хайс хашаа барих зэрэг/-д оролцлоо

Хошууч Г.БАВУУДОРЖ



ФОТО АГШИН

Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ



АНУ-ЫН АРМИЙН СҮҮЛЧИЙН НИСЭХ ОНГОЦ КАБУЛААС ХӨӨРЧ, 20 ЖИЛ ҮРГЭЛЖИЛСЭН АФГАНИСТАНЫ ДАЙН ӨНДӨРЛӨЛӨӨ



Орон нутгийн цагаар Мягмар гарагийн шөнө Кабул хотоос АНУ-ын армийн сүүлчийн нисэх онгоц хөөрч, 20 жил үргэлжилсэн Афганистаны дайнд цэг тавьжээ.

"Афганистанаас АНУ-ын болон гурав дахь орны иргэдийг, эрсдэлтэй бүлгийн Афганчуудыг гаргах ажиллагаа дууссаныг би үүгээр зарлаж байна. Зүүн эргийн цагаар өчигдөр 15:29 цагт сүүлчийн С-17 нисэх онгоц Хамид Карзайн нэрэмжит олон улсын нисэх буудлаас хөөрлөө" хэмээн АНУ-ын Армийн төв тойргийн командлагч, тангисийн хүчний генерал Кеннет Маккензи мэдэгдсэн байна.

Ерөнхийлөгч Жо Байдене засаг захиргаа өнөөдөр Афганистанаас гаргах сүүлчийн хугацааг зарлаад байсан юм. Талибанчууд уг үйл явдлыг тэмдэглэн ёслолын буудлага зохион байгуулжээ.

2001 онд Афганистаны дайн эхлэхэд түлхэгдэн унасан Талибаны дэглэм ийнхүү 20 жилийн дараа дахин төрийн эрхийг авч байна.

Исламын хэт үзэлт Талибаны дэглэмээс зугтсан олон мянган Афганчууд эх орноосоо дүрвээд байгаа. Талибанчууд нийслэл Кабулд орж ирсэн наймдугаар сарын дунд үеэс хойш тус хотын олон улсын нисэх буудал дүрвэгчдээр дүүрсэн юм.

Өнгөрсөн хугацаанд АНУ-ын тал Афганистанаас 122,300 орчим хүнийг нүүлгэн

гаргажээ. Дүрвэхийг хүссэн олон мянган афган хүнээс гадна 250 орчим америк хүн Афганистанаас явж чадалгүй үлдсэн байна.

Пүрэв гарагт Кабулын нисэх буудалд террорист халдлага гарах үеэр 170 гаруй хүн алагдсаны 13 нь АНУ-ын цэргийн алба хаагчид байв. Баасан гарагийн орой АНУ-ын тал уг халдлагыг төлөвлөж, зохион байгуулсан орон нутгийн Исламын Улс бүлэглэлийн хоёр гишүүнийг Афганистаны Нангархар мужид дроны цохилтоор устгасан юм.

Хоёр дахь халдлагыг үйлдэхээр нисэх буудал руу явж байсан тэсрэх бөмбөгтэй автомашиныг АНУ-ын арми Ням гарагт аюулгүй болгосон байна.

Энэ үеэр террористуудаас гадна энгийн номхон 10 иргэн алагдсаны долоо нь хүүхэд байсан тухай гэрчүүд мэдээлжээ.

Даваа гарагт Исламын Улс бүлэглэл Кабулын нисэх буудал руу пуужингууд харвасныг АНУ-ын арми амдаж устгасан байна.

Трампын засаг захиргаа 2020 оны хоёрдугаар сард Талибанчуудтай тохиролцоо хийсний дараа АНУ-ын цэргийг Афганистанаас гаргах ажиллагаа яригдаж эхэлсэн юм. Ерөнхийлөгч Байден уг төлөвлөгөөг үргэлжлүүлэн хэрэгжүүлжээ.

Эхэн үедээ Америкчуудын ихэнх нь

Афганистанаас цэргээ гаргахыг дэмжиж байсан бол сүүлийн үеийн судалгаанд оролцогчид Байдене засаг захиргааны цэрэг гаргах үйл ажиллагааг шүүмжлэх болсон байна.

Кабулын албан ёсны Засгийн газрыг Талибанчууд маш богино хугацаанд түлхэн унагаж, Афганистан Улсын ирээдүйг тодорхойгүй нөхцөл байдалд орхисон нь Байдене нэр хүндийг унагах гол шалтгаан болжээ.

Америкийн түүхэнд хамгийн урт дайн болох Афганистаны дайн 2001 оны есдүгээр сарын 11-ний террорист халдлагын дараа эхэлсэн юм.

Халдлагыг үйлдсэн Аль Кайда байгууллагын толгойлогч Осам бин Ладеныг 2011 онд устгасан ч уг террорист байгууллага үйл ажиллагаагаа явуулсан хэвээр байгаа.

Аль Кайдагаас гадна Исламын Улс террорист бүлэглэлийн Афганистан дахь салбар сүүлд шинээр байгуулагдсан юм.

2001 оноос хойш АНУ нийт \$2.26 их наядыг Афганистаны дайнд зарцуулжээ. Энэ хугацаанд Афганистаны арми, цагдаагийн 66,000 алба хаагч, энгийн номхон 47,000 орчим иргэн амь үрэгдсэн байна.

Энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар Афганистанд АНУ-ын 2,448 цэргийн алба хаагч амь үрэгджээ.

Эх сурвалж: Business Insider

ӨНӨӨДӨР АЖИЛЛАХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЦЭГҮҮД

Улаанбаатар хотод өнөөдөр дархлаажуулалтын явуулын дөрөв, суурин 45 цэг 09:00-17:00 цагт ажиллана.

Эдгээр цэгт 70 багийн 363 эмч, ажилтан ажиллаж, 9,112 иргэнийг дархлаажуулахаар төлөвлөөд байна.

Нийслэлийн хэмжээнд өчигдөр I тунд 771, II тунд 2,548, III тунд 6,944 буюу нийт 10,263 иргэн дархлаажуулалтад

хамрагджээ. Вакцинжуулалт эхэлснээс хойш нийслэлийн нийт хүн амын I тунгийн хамралт 74.1 хувь, II тунгийн хамралт 69.3 хувь байна. Мөн зорилтот бүлгийн буюу 2,682 жирэмсэн эх, 12-15 насны 58,416, 16-17 насны 23,869 хүүхэд тус тус дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдлаа гэж НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсээс мэдээлэв.

